



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/45

Онги

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/125 дугаар тушаал, Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/366 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 25 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулсугай.

2. Отор нүүдлийн судалгааг гаргаж, отроор явсан малыг тарихад шаардлагатай шатахууныг Орон нутгийн хөгжлийн сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Болоржаргал), санхүү албаны дарга (Р.Тунгалагтуяа), нягтлан бодогч (Э.Наранцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тов мэдээг малчид, мал бүхий иргэдэд хүргэн, бэлэн байдлыг хангуулж, малыг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын ажлыг чанартай хугацаанд нь стандартын дагуу хийж гүйцэтгэхийг Мал Эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Б.Цэнгэлмаа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн Улсын байцаагч (Ц.Саранчимэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЛУВСАНРАГВА